

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Эрдэнэбаяр	Дугаар	L151
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Баянбулаг
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Зоч лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Билүүтэйн хүрээ, Хар усны хүрээ	Сүм хийдийн дугаар	БХГБ 085, БХБГ 086
Одоогийн сүм хийд	Амгаланзаан	Сүм хийдийн дугаар	БХГБ 018
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын **Амгаланзаан** хийд болон Гурванбулаг сумын Билүүтэйн хүрээ, Хар усны хүрээ

Асуулт:-Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын **нутагт байсан** Билүүтийн хүрээний тухай ярьж өгнө үү.

Хариулт:-Билүүтийн хүрээ гэж анх хэдэн онд байгуулагдсан юм би мэдэхгүй, жаахан байсан. Намайг жаахан байхад манайх чинь 5 настай хүрээнд суугаад, тэгээд 22 оны эсэргүүн хүртэл байсан юм байна лээ, тэгээд хүрээ тарсан гэдэг юм. Манай Да хүрээнд Билүүтийн хүрээнээс нэг хувилгаан лам очиж суусан байгаа юм. Тэр гэвш болоод сайн гэвш **болчихоод** нутагтаа ирж байсан юм гэнэ лээ. Манай өвөг эцэг Дархан Ядамжав гэж хүн бас хэд хэдэн хүрээний лам байсан. Дархан Ядамжавын хүү болохоор миний эцэг Дамдинсүрэн гээч хүн 5 настай шавилан суусан. Тэгээд Гангаа лам гээд их ярьдаг байсан. Ах дүү хоёр лам байсан юм гэнэ лээ. Тэр лам нарт их шавь орж, тэд нь их эрдэм номтой **чойрын** номонд их боловсорсон, ер нь **чойр** үздэг, их бага хоёр сахиустай, тэр хоёр сахиус нь амилсан байсан гэдэг юм.

Чойжинламын сахиустай. Тэр сахиус нь тахилга нь гэхээр 260 тахиад тэгэхээр өөрсдөө аяндаа хүрч ирээд шүтээнүүдээ хараад голлоод тэгээд цэглэсэн гэж ярьж байсан. Сүүлд нь **Дасаажав** лам гэж Гурванбулагт хамгийн сүүлчийн лам байж байгаад таалал төгссөн. Манай эцэг Төмөрийн Дагва гээч хүнтэй нэг гэрт байсан. Төмөрийн Дагва гээч хүн **зоч** хүн байсан. Одоо Төмөрийн Дагвын хүү Гурванбулагт Цэдэндорж дарга гэж байгаа. Тэр Цэдэндорж дарга харин түүх намтрыг эцгээсээ нэлээн дуулсан байж болзошгүй. Би бол багш нараасаа сонссоныгоо айлдаж байгаа юм.

Асуулт:-Билүүтийн хүрээ хэд орчим лам **хуврагатай** байсан юм бол?

Хариулт:-Олон ламтай байсан гэдэг юм. Ямар ч **байсан** 20, 30-аар тогтохгүй байх. Гадуур бас данстай лам нар байдаг, хааяа **мацагаар** ирдэг. Жасын адуу Билүүтийн Улаан **хадын** бууцанд жасын үхэр байдаг. Цагаан **хадын** бууцанд жасын адуу байсан гэдэг билүү дээ. Тэгээд адуугаа малладаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Хэд орчим малтай байсан юм бол жас нь?

Хариулт:-Мэдэхгүй. Сайн мэдэхгүй, их л олон малтай байсан юм шиг байна лээ. Ер нь их баян жастай газар байсан **байна** лээ шүү. Анх нь Билүүтийн хүрээг эхлээд үүсэхэд нь Эрдэнэ мандалын хүрээ гэж бий болгож байсан юм билээ?

Асуулт:-Хэд орчим оны үед үүссэн юм бол?

Хариулт:-Мэдэхгүй, 30 хэдэн оноос өмнө байх, хувьсгалаас өмнө үүссэн юм шиг байна лээ.

Асуулт:-Билүүтийн хүрээг юугаар барьсан юм бол?

Хариулт:-Тоосго. Шавар туйпуу. Билүүтийн хүрээнд манай Гурванбулагийн баян Шагдарсүрэн гээч хүн хандив өргөж, хүү гардаггүй хүн байсан юм гэнэ лээ. Тэгээд Архангай руу далан хайнагийн шар явуулж мод ачаад тэгээд Дүйнхэрийн дуган гэдгээр оруулаад тэгээд хүүтэй болж байсан гэдэг юм. Хүү нь хүнхэр Дарамбазар гэж их баян хүний хөрөнгөөр тоглосон тийм мундаг хүн байсан, тэгээд Балдан **зоч** гээд хүн дээр очоод тэр Балдан **зоч** за чи нэг буян хийгээд дуган **байгуулаатах** тэгвэл ганц хүүтэй болох нь гэж айлдаад тэгээд болсон юм гэнэ лээ.

Гурванбулаг бол тахилгагүй уул байгаа юм. Билүүтийн хүрээг эхлээд Эрдэнэ мандалын хүрээ гэж нэрлэдэг байсан юм. Эрдэнэ мандалын хүрээ гэдэг байсан чинь тэр савдаг нь **догшроод** дийлдэхгүй байхаар нь тэр доод аманд нь Билүү толгой гэж байдаг. Тэр савдагтай газар гэнэ гээд тэр Хар уул байдаг, тэр уулын нэрээр Билүүтийн хүрээ гэж нэр өгсөн юм гэнэ лээ.

Асуулт:-Билүүтийн хүрээ аль урсгал байсан юм бол, шарынх уу, улааных уу?

Хариулт:-Шарынх. Чойрын ном голлож үздэг шарынх. Билүүтийн хүрээнээс төрсөн **зоч** лам Балдан **зоч** гэж алдартай хүн. Өөрөө нэг их ирдэггүй, шавь нар нь. Билүүтийн хувилгаан лам гэдэг бол гэдэг улсын аварга малчин Дашравдангийн ээжийнх нь ах нь. Тэгэхээр нагац ах нь юм байна. Тийм хүн байсан юм гэнэ лээ. Алдрыг нь мэддэггүй юм. Шавь хүмүүс олон байсан болохоор хэлж чаддаггүй байсан болов уу. Хар усны хүрээ бол яг хувьсгалын үеэр хүрээ хийдүүдийг устгаж байх үеэр **Богчин** дөрвөлжин дээрээс Хар усны хүрээг үхэр буугаар буудаад сөнөөсөн гэдэг юм.

Асуулт:-Тэр үеийн хийдийн хамба лам хэн гэдэг хүн байсан бэ?

Хариулт:-Мэдэхгүй. **Тэрэн** дээр Нацагдорж лам гэдэг **жодын** хурлын хамба лам байсан юм гэнэ лээ. Улааны шашин байсан шүү дээ. Улааных, шарынх хоёр байсан, хоёр талдаа байсан.

Асуулт:-Хар усны хийд үү?

Хариулт:-Тийм, Хар усны хийд. Хоёр хүрээтэй, наана нь шар юугаа ч үздэг, **чойроо** ч үздэг. **Жод,лүйжингийн** юм лам нар нь бас тусдаа хийдтэй, тусдаа дугантай. Гэхдээ дамар нь дуулдахгүйгээр жаахан **зайтайдуу** тийм байсан юм гэнэ лээ. Тэнд манай хувилгаан Доржсүрэн гээч хүн төрсөн гэж.Дамбын Доржсүрэн гээч хүн. Одоо манайд ирж байсан хүмүүс олон хүүхэдтэй буурайдуу амьдралтай л байсан биз. Тэгэхэд гэр нь шатаж гэнэ нэг хавар. Ядарсан юм оронгүй боллоо, хэдэн хүүхэд шатаж өгөөгүй бол **яахав** гэсэн. Өглөө боссон чинь хүүе байна гэж, гэр нь байж байдаг байна, хоёр адуучин давхиад очтол тооноороо багана цухуйлгачихсан байсан гэсэн. Тэр

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

үед хүн төрөхөөр орж болохгүй гэсэн дохио байдаг юм гэнэ. **Ацтай** багана тооноороо **цухуйлгачихаад**. Үндсэндээ энэ чинь болохгүй гэсэн дохио юм гэнэ. Тэрнийг нь **ойлгочихоод** за ядарсан юм гээд шөлний хонинд яваад шөл эхэд нь уулгаж байсан гэдэг юм. Тэгээд 3 настайдаа тодроод тэгээд тэр улааны шашны хийд тэр хурал дээр сууж байсан. Улааны ёсны хийд нь болохоор дээр үед одоогийн Урт цагаан гэж бий шүү дээ. Тэр Урт цагааны наахна талд Өндөр хоршоо гэж байсан байна.

Асуулт:-Улаанбаатарт?

Хариулт:-Тийм. Улаанбаатарт. Өндөр хоршооны хажуухан талд **Жодын** хороолол байсан байгаа юм. Тэндээс тасарч ирээд тэр Нацагдорж ламтан морилж ирээд тэгээд тэр **Жодын** ёсны хийдийг байгуулаад тэр Нацагдорж ламтан болохоор манай Сангийн далай хүрээний **Наран хутагтын** багш нь байсан гэдэг. Ер нь л номын багш нь байсан гэсэн.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-Лав л **Жодын** лам нар 30-аад лам нар байсан гэсэн, наадуул нь тодорхой мэдэхгүй юм. **Билүүгийнх** нь олон дугантай л юм байна лээ. 10-аад дуган байсан юм шиг байдаг шүү, буурийг нь үзэхэд.

Асуулт:-Энэтхэг, Төвдөөс том лам нар тэнд байсан уу? Чойрын ном заадаг ч юмуу?

Хариулт:-Зааж байсан гэсэн. Чойр дэглүүлж байсан юм гэнэ лээ.**Сэр** дэгээр дэглэж байсан энэ **Билүүтийнхэн** байна. **Жодын** лам нар морилж ирээд тэр нутагт их ядуучууд олон байж тэгээд багшийн овоо гэж том овоо байгаа. Тэр овоог адислаад овоог бариулаад тахичихсан чинь их бороо орж, зун сайхан болоод нууран дотроос, манай Хөх нуур гэж алдартай нуур байгаа, тэрнийг тойроод 108 нуур байсан гэдэг юм. Тийм ч юм шиг байна лээ. Одоо цөөн тооны нуур байдаг юм. Тэгээд тэр нууран дундаас үхэр гарч ирээд айл айлын цөөхөн үхэртэй, ганц хоёр үнээтэй айлын зэлэн дээр очоод тэгээд байсан, алтан үстэй тийм үхэр. Одоо болтол айлуудад зүс нь байдаг юм. Гурванбулагийн хагас нь, томчуудын. Тэгээд Гурванбулаг үхэр нь өсөөд нөхцөлгүй их сарлагтай болсон гэдэг юм. Манай Архангайн наад зах дээр байгаа шүү дээ, Гурванбулаг чинь.

Асуулт:-Билүүтийн хүрээний лам нар ямар уул овоогоо тахидаг байсан бол?

Хариулт:-Билүүтийн **хүрээний** лам нар хойд талынхаа Түгээ овоог тахидаг **байсан**, Алтангэрэлийн овоог тахиад тэгээд энгэр дээр нь Хийморийн овоо гэж байдаг юм, тэрнийгээ **тахичихаад**, тэгээд дээшээ яваад төвийн овоогоо **тахичихаад**, Төвийн овоон дээрээс Гурванбулагийн Хар усны нуурын өндөр Жаргалант, Дөрвөн уул, Тэгш буянт хайрхан гээд байдаг юм, Хавтгай улаан гээд манай баруун түргэний, Завхан аймгийн Отгон сүмн над зах дээр хиллэсэн, тэр **уулнууд** харагддаг, Гурванбулаг уул харагддаг тийм юм гэнэ лээ. Отгонтэнгэр уулын жасынх нь нярав нь Баянхайрхан юм гэсэн. Жинхэнэ жасынх нь эзэн нь Даамал нь Гурванбулаг хайрхан юмаа гэж.

Асуулт:-Цагаан идээгээр тахидаг байна уу?

Хариулт:-Шүүсээр тахихгүй, зүгээр л сүүтэй цай, тавгийн идээгээ аваачиж тавиад, бяслаг **өрөмөө тавьчихаад** тэгээд тахидаг.

Асуулт:-Дээр үед тахилга хийхэд морь уралдах, бөх барилдах, наадам болдог байв уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Нэг сүрхий наадам хийдэггүй байсан шиг байна, Алтангэрэлийн овоон дээр бол Хүүхдийн овоо гэж байдаг юм л даа, тэр **Цагаан мөсний** наад талд. **Цагаан мөснийхөө** эхэн дээр хувинтай тараг нь байдаг юм. Тэндээ идээгээ **тавьчихаад**, Алтангэрэлийнхээ овоон дээр тавагтай идээгээ тавиад тэгээд лам банди нараа **ноцолдуулчихаад**, тэгээд **яхав** ард түмэн нь их цуглаад ирэх юм бол зохих хэмжээний унасан морио ч хамаагүй уралдуулаад тэгээд тэмдэглээд өнгөрөөчихдөг.

Асуулт:-Хар усны хүрээний лам нар ямар уул овоогоо тахидаг байсан юм бол?

Хариулт:-Хар усны хүрээний лам нар Өлзийтийн овоог тахидаг байсан.

Асуулт:-Хийдээсээ **ойрхон** уу?

Хариулт:-Ойрхон. Өлзийтийн овоо гэж байдаг юм. Өндөр Өлзийтийг тахидаг байсан.

Асуулт:-Тахидаг ёс нь ямар **байхав?**

Хариулт:-Тахидаг ёс нь манайхны мөн л нэгэн адил.

Асуулт:-Идээ цагаагаараа тахиад?

Хариулт:-Тийм, идээ цагаагаараа тахиад л. Тийм архи хар идээ хэрэглэдэггүй байсан юм билээ. Лусын буулттай өдөр тааралдуулаад зун 5 **сараас** хойш л тахидаг байсан юмуу. Ер нь зуны сар гараад ирлээ, бороо хур орох цаг боллоо гээд тэгээд тахидаг байсан гэж. Тэгэхээр Отгонтэнгэр уулаа тэр Төвийн овоон дээрээс тахидаг. Төвийн овооноос хойшоо Сэрвэн гэж байгаа, Сэрвэнгийн овоон дээр 13 овоотой байдаг. 13 овоон дээр 13 сангаа тавиад Отгонтэнгэрээ тахиад, бас Баруун Алтайг тахидаг байсан байна. Баруун Алтай чинь 13 сангаар тахигддаг. Алтай сан гэж бас тусдаа байдаг. Тэгээд баруун аймгийнханд ер нь Улаанбаатар хотод бол Алтай савдаг нэхэгдэж байна, 13 сан нэхэгдэж байна гэж их буудаг шүү дээ. Тийм байдаг юм. Алтайтайгаа их холбоотой юм билээ. Нэгэнт л баруун бүсдээ орж байгаа болохоор.

Асуулт:-Хэлмэгдүүлэлтийн үеэр энэ хоёр хүрээний том лам нар яасан, баригдсан уу?

Хариулт:-Тэр хувилгааныг баривчлаад аваад явчихсан юм гэнэ лээ. Ямар ч байсан 200-гаад ламтай байсан юм шиг байгаа юм, тэр хоёр хүрээ нийлээд. Тэгээд шавь нар нь хуйлраад дагаад яваад байсан. За та нар юунд нь хуйлраад намайг дагаад байгаа юм, 2 хүн баривчлаад буутай хоёр хүн, дундаа морьтой аваад явсан чинь юунд нь намайг дагаад хуйлраад байгаа юм, муу ч гэсэн төр юм шүү, сүлдэнд нь сүжигтэй яваарай, **чү** гээд морио ташуурдаад эргэж харалгүй явчихсан юм гэнэ лээ.

Асуулт:-Тэгээд тэр хүнийг яасан?

Хариулт:-Хороогдсон.

Асуулт:-Өөр 37 оны үед баригдсан лам нараас та мэдэж байна уу?

Хариулт:-Мэдэхгүй. Хэлмэгдсэн л гэдэг юм. Манай эцэг бол хэлмэгдэж явсан, 10 жилийн хорих ял авах гээд, хүний **хойтох** уншчихаад тэгээд худлаа галзуу нэртэй байж нэг амиа аварсан.

Асуулт:-Аль хүрээнд шавилж байсан юм?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Билүүтийн хүрээнд, Дамдинсүрэн гээч хүн. Тэгээд тэр Ядамжав гээч хүн бол насаа наslaад Улаанбаатар хотод байж байгаад зурхайч Дамдинпүрэв гээч эцэг нь байгаа юм. Манай эцэг хоёр нэг эцэгтэй, эх тусгаар улсууд байхгүй юу.

Асуулт:-Билүүтийн хүрээний лам нарыг баригдсанаас хойш бурхан шүтээн, сүм дуганыг яасан юм бол?

Хариулт:-Балдан зочыг хэлмэгдүүлсэн, Билүүтийн хүрээнээс. Энэ Хайрханы өвөрт өвлийн харанхуй хүйтэн шөнө их олон морьтой хүмүүс хүрч ирээд шөнө баривчлаад аваад **явчихаж** байсан юм гэнэ лээ. Тэгээд гэрийг нь битүүлээд хамаг хөрөнгийг нь хураагаад.

Асуулт:-Лацдаж, ломбодоод. Тэгээд эргэж ирээгүй юу?

Хариулт:-Тийм. Эргэж ирээгүй. Хэлмэгдсэн лам нарыг энэ Заг дээр аваачиж модон байшинд хийгээд жадаар хатгаад багтахгүй болохоор нь жадаар хатгаад бүр ингээд мал шиг амьдаар нь хураачихсан, тэгээд доод талынх нь чадалгүй нь үхээд, чадалтай нь дээр нь байж байдаг. Тэгээд тэр чинь байшингаа эвдээд. Олон хүн байсан. Тэгээд заримыг нь багтахаа байхаар нь үхэр тэрэгний **арлаас** ар татуурга хийгээд хүлчихдэг байсан юм гэнэ лээ. Тэгээд л байж байдаг, шалдан.

Асуулт:-Билүүтийн хүрээний бурхан шүтээн, сүм дуганыг яасан юм бол?

Хариулт:-Шагдарсүрэнгийн хүрэн дуган гэж байсан байна. Тэр Дүйнхэр бас хурдаг байж. Ядам хурдаг байсан байна, **Чойр** үздэг. Чойр чинь ядам л даа. Ядмаа 360 тахиж, **Намжилдаваг** гэж их даваг байдаг юм, тэрнийг цам болгож цохиж тахидаг байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Билүүтийн хүрээний гол шүтээн нь Ядам бурхан байсан гэх үү?

Хариулт:-Билүүтийн хүрээний гол шүтээн нь Лхам бурхан байсан. Битүүний шөнө **Лхам яамладаг** байсан юм гэнэ лээ, Билүүтийн хүрээ.

Асуулт:-Цам, **Майдар гардаг** байсан үү?

Хариулт:-Цам, **Майдар** хурдаг байсан юм гэнэ лээ. Манай эцэг Чадлаа унзад гээч хүн байдаг байсан гэж. Самдангийн их **Гэсгүй** байсан Лхагвасүрэн гуай ордог байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Хэдэн сард болдог байсан юм бол?

Хариулт:-Зуны эхэн сард юмуу даа. Тэр хавьд л болдог байсан шиг байна лээ. Цам гардаг, Майдар хурдаг, **Майдар** эргэдэг. Азар гээд. Билүүтийн хүрээ **Лхам, Жамсран** хоёр хурдаг. Их шүтээн нь Лхам, бага шүтээн нь Жамсран байсан юм.